

ДАМЖУУЛАН ОЛГОХ ТӨСЛИЙН ЗЭЭЛҮҮДИЙН 2017 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

Монгол улсын Засгийн газар 1994 онд Азийн хөгжлийн банктай, 1995 онд ХБНГУ-ын Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу Монголбанк КфВ банк болон АХБ-ны төслийн зээлийг банкуудад дамжуулан олгох үүрэгтэй оролцож байна.

1. КфВ банкны ЖДҮ-ийг дэмжих төслийн зээл

Төслийн зорилго: Экспортын чиглэлийн ЖДҮ-ийг хөгжүүлэх, санхүүгийн секторыг дэмжих.

Эх үүсвэр: Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 40 жилийн хугацаатай 8.7 сая еврогийн зээлийг жилийн 0.75 хувийн хүүтэйгээр хүлээн авсан.


КфВ банкнаас Монголбанкинд олгосон зээлийн эргэн төлөлт: Монголбанк КфВ банкинд жилд 2 удаа хуваарийн дагуу эргэн төлөлт хийдэг бөгөөд анх зээл авсанаас хойш нийт 2.5 сая еврог КфВ банкинд төлсөн. Ингэснээр энэхүү зээлийн үлдэгдэл 2017 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 6.04 сая евро байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. КфВ төслийн зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл /евро/

	2016.II	2016.III	2016.IV	2017.I	2017.II
Эхний үлдэгдэл	6 469 117,87	6 327 266,00	6 327 266,00	6 185 414,13	6 185 414,13
Үндсэн зээлийн төлбөр	141 851,87	0,00	141 851,87	0,00	141 851,87
Хүүгийн төлбөр	24 259,19	0,00	23 727,25	0,00	23 194,00
Эцсийн үлдэгдэл	6 327 266,00	6 327 266,00	6 185 414,13	6 185 414,13	6 043 562,26

Монголбанкнаас Банкинд олгосон зээл: Банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанк 250 000 хүртэлх еврог 5 жилийн хугацаатай банкуудад дамжуулан олгодог. Банк Монголбанкинд жилд 2 удаа хуваарийн дагуу буцаан төлдөг бөгөөд оролцогч банкинд олгосон зээлийн үлдэгдэл 4.34 сая евро байна (Зураг1).

Зураг 1. КфВ төслийн зээлийн үлдэгдэл, дамжуулан олгосон дүн /евро/



Банкуудын ААН-д олгосон зээл: КфВ банкны төсөл манай улсад хэрэгжиж эхэлснээс хойш уг төсөлд нийт 160 ЖДҮ зээлд хамрагдаж, 78.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авсан байна. Тайлант улирлын эцсийн байдлаар 67 ЖДҮ эрхлэгч ААН-үүд 12.2 тэрбум төгрөг /5.46 сая евро/-ийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нэг зээлдэгчид ногдож буй дундаж зээлийн хэмжээ 182.6 сая төгрөг байна.

2. АХБ-ны Ажлын байр нэмэгдүүлэх (АБН) төслийн зээл

Төслийн зорилго: Монгол улс, АХБ-ны хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн зорилго нь хувиараа хөдөлмөр эрхлэх хэлбэрээр жижиг үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийг дэмжих, мөн ажлын байр нэмэгдүүлэхэд оршино.

Эх үүсвэр: Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу 2154.0 мянган зээлжих тусгай эрхтэй (ЗТЭ) тэнцэх валютыг 40 жилийн хугацаатай зээлсэн.


АХБ-наас Монголбанкинд олгосон зээлийн эргэн төлөлт: Монголбанк АХБ-нд жилд 2 удаа хуваарийн дагуу эргэн төлөлт хийдэг бөгөөд хамгийн сүүлд 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдөр 40,800.00 ЗТЭ-ийн зээлийн үндсэн өр, 7,227.24 ЗТЭ-ийн хүүгийн төлбөрийг эргүүлэн төлсөн.

Анх зээл авсанаас хойш нийт 767.3 мянган ЗТЭ-ийг төлж 2017 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар зээлийн өрийн үлдэгдэл 1,345.9 мянган ЗТЭ буюу 4.6 тэрбум төгрөг* байна.

*-2017 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн ханшаар тооцов.

Банкинд дамжуулан олгосон зээл: Банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанк 30 сая хүртэлх төгрөгийг 3 жилийн хугацаатай банкуудад дамжуулан олгодог. Төслийн хүрээнд өссөн дүнгээр нийт 16.9 тэрбум төгрөгийн зээл банкинд дамжуулан олгосон. 2017 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар оролцогч банкинд олгосон эх үүсвэрийн үлдэгдэл 0.85 тэрбум төгрөг байгаа бөгөөд төслийн эргэлтийн санд зээлдүүлэх боломжтой 3.7 тэрбум төгрөгийн эх үүсвэр байна (Зураг 2).

Зураг 2. АХБ-ны АБН төслийн зээлийн үлдэгдэл, дамжуулан олгосон дүн



Банкуудын тайлангаас үзэхэд төслийн хүрээнд олгосон зээлийн үр дүнд зээлийн үлдэгдэлтэй байгаа 58 аж ахуй нэгж нийт 232 ажлын байр бий болгосон байна.